



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/18

Чойбалсан

Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын эзэмшилд байгаа 2012 онд ашиглалтад орсон 20,800,000.0 (Хорин сая найман зуун мянга) төгрөгийн үнэ бүхий 27-24 ДОО улсын дугаартай, UAZ 220692-033 маркийн автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2.Автомашин шилжүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, үндсэн хөрөнгийн данс, бүртгэлээс хасалт хийж тайлан балансад тусгаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч Б.Оджаргалд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс (Я.Эрдэнэтуяа)-т даалгасугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА